

**ТЭНГЭР ДААТГАЛ ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2025 оны 04 сарын 26 өдөр

Улаанбаатар хот

Тэнгэр Даатгал ХК (цаашид “Компани” гэх)-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2025 оны 04 дугаар сарын 26-ны өдөр 10:00 цагаас 11:30 цагийн хооронд Улаанбаатар хот, компанийн албан ёсны фэйсбүүк <https://www.facebook.com/tengerinsurance/> хаягаар дамжуулан цахим хэлбэрээр хуралдав. Санал хураалт болон асуултыг <https://www.investmentexpo.mn/> цахим хаягаар хураав.

Хурлын дарга: Шаравпэлжээгийн ГАНТУЯА

Хурлын нарийн бичгийн дарга: Балдангийн ЭНХТҮВШИН

Тооллогын комисс: Т.Батмагнай/Комиссын дарга/

Гишүүд: Ж.Ууганбилэг

Хуралд оролцсон хувьцаа эзэмшигч нарын тоо: 18

Хуралд оролцсон хувьцаа эзэмшигч нарын саналын эрхтэй хувьцааны тоо: 49,055,082 ширхэг

Хурлын ирц: 81.76 хувь буюу дийлэнх олонх.

НЭГ. МЭДЭЭЛЭЛ

Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга Б.Энхтүвшин “Тэнгэр Даатгал” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдах шийдвэрийг 2025 оны 03 сарын 14-ны өдрийн ТУЗ-ийн ээлжит хурлаас шийдвэрлэсэн тухай мөн уг шийдвэрийн дагуу Хувьцаа эзэмшигчдийн хурлын зарыг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр 2025 оны 03 сарын 29-ны өдөр, 2025 оны 04 сарын 11-ний өдрүүдэд тус тус мэдээлээснийг танилцуулав.

Хурлын зар болон хурлын материалыг Санхүүгийн зохицуулах хорооны 244 тоот тогтоолоор баталсан “Хувьцаат компанийн хурлын зар хүргэх, хяналт тавих журам”-ын дагуу 2021 оны 03 сарын 17-ны өдрийн дотор брокер, дилерийн компаниудад цахим болон хэвлэмэл хэлбэрээр хүргүүлж, хувьцаа эзэмшигчдийн хурлын материалтай танилцах боломжоор хангаж ажилласан болохыг мэдэгдэв.

Мөн Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүртгэлийн өдрийг 2025 оны 04 сарын 04-ны өдрөөр тогтоосныг танилцуулав.

Тооллогын комиссын дарга Т.Батмагнай: Хувьцаа эзэмшигчдийн хурлын ирц хураалтын аргачлал болон “Тэнгэр Даатгал” ХК-ийн ТУЗ-ийн хурлын шийдвэрээр томилогдсон Тооллогын комиссоос ирүүлсэн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд ирсэн хувьцаа эзэмшигчдийн ирцийн бүртгэлийг танилцуулав.

Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах болсон шалтгаан, хуулийн үндэслэлийг танилцуулж, хурлаар хэлэлцэх асуудал, хурлын дэгийг танилцуулав.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын дарга Ш.Гантуяа нээлтийн үг хэлснээр хурал албан ёсоор эхлэв.

ХОЁР. ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ

1 дүгээр асуудал: Компанийн 2024 оны бизнесийн болон үйл ажиллагааны тайлан танилцуулах;

2 дугаар асуудал: Компанийн 2024 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын дүгнэлтийг танилцуулах;

3 дугаар асуудал: Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах;

4 дүгээр асуудал: Компанийн ногдол ашиг тараах эсэх талаарх ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг танилцуулах;

1 ДҮГЭЭР АСУУДАЛ:

Компанийн 2024 оны бизнесийн үйл ажиллагааны тайлан танилцуулах;

1. Хэлэлцсэн нь:

Танилцуулсан: Тэнгэр Даатгал ХК-ийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Б.Баянмөнх

Танилцуулгын гол агуулга: Тэнгэр Даатгал ХК-ийн 2024 оны санхүүгийн үр дүн болон үйл ажиллагааны тайланг товч танилцуулав.

2024 оны орлого үр дүнгийн тайлан: Нийт хураамжийн орлого нь 69%-иар өсөж, 28.1 тэрбум, цэвэр ашиг нь 39%-иар өсөж 7.2 тэрбум төгрөгийн татварын дараах цэвэр ашигтай ажилласан байна. 2024 онд хөрөнгө оруулалтын дүн 47.5 тэрбум₮-т хүрснээр хөрөнгө оруулалтын орлого өмнөх оноос 58%-иар нэмэгдэж, нийт хөрөнгө оруулалтын өгөөж 6.3 тэрбумд хүрч өмнөх оноос 71%-иар өссөн нь цэвэр ашиг 39%-иар өсөхөд нөлөөлсөн байна.

2024 оны санхүүгийн тайлан: Мөнгөн хөрөнгө буюу Хөрөнгө оруулалтын дүн 47.5 тэрбум төгрөгт хүрч өмнөх жилээс 17,4 тэрбум төгрөгөөр өссөн. Нийт хөрөнгө 56,1 тэрбум төгрөгт хүрсэн.

2024 оны ашигт ажиллагааны үзүүлэлт: Хохирлын харьцаа 40,1%, Зардлын харьцаа 55,3%, Нийлмэл харьцаа 95,4%,

Тэнгэр даатгал ХК нь нийгмийн хариуцлагын хүрээнд ASUUNA платформ, Эрүүл мэндийн нэгдсэн сан болох EDOCTOR вэб сайт, “Тэнгэр Төгөл” зэргийг танилцуулав.

2 ДУГААР АСУУДАЛ:

Компанийн 2024 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын дүгнэлтийг танилцуулах;

1. Хэлэлцсэн нь:

Танилцуулсан: Тэнгэр Даатгал ХК-ийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Б.Баянмөнх

Танилцуулгын гол агуулга:

“Тэнгэр Даатгал” ХК-ны 2024 оны 08 сарын 01-ны өдрийн ТУЗ-ийн ээлжит хурлын 24/018 тоот тогтоолоор “Тэнгэр Даатгал” ХК-ны 2024 оны Санхүүгийн тайланг батлах хөндлөнгийн аудитын компаниар “Нексия Глобал Монголиа Аудит” компанийг сонгосон. “Нексия Глобал Монголиа Аудит”-ын фирм нь Олон улсын аудитын франчайз бөгөөд “Тэнгэр Даатгал” ХК-ийн санхүүгийн тайланг сүүлийн 2 жил хийсэн.

Дүгнэлтийн товч агуулга: Бид “Тэнгэр Даатгал” ХК-ийн 2024 оны 12 сарын 31-ний өдрөөрх Компанийн санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавал болсон үеийн жилийн дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо болон бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр дээр нэрлэсэн санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаарх Компанийн санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс гаргасан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв толилуулсан байна.

3 ДУГААР АСУУДАЛ:

Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах;

1. Хэлэлцсэн нь:

Танилцуулсан: “Тэнгэр Даатгал” ХК-ийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Энхтүвшин

Танилцуулгын гол агуулга:

“Тэнгэр Даатгал” ХК-ийн эрхэм харилцагч, хувьцаа эзэмшигч, хамтран ажиллагч та бүхэнд 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн дүгнэлт, 2024 оны зорилго зорилтуудын гүйцэтгэлийг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаар хэлэлцэн баталсан дүгнэлтийг та бүхэнд танилцуулж байна.

Санхүүгийн үйл ажиллагаа:

“Тэнгэр Даатгал” ХК-ийн 2023 оны 12 сарын 14-ний өдрийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ээлжит хурлын №23/013 тоот тогтоолоор “Тэнгэр Даатгал” ХК-ийн 2024 оны Бизнес төлөвлөгөө, үйл ажиллагааны стратегийг баталсан. “Тэнгэр Даатгал” ХК нь 2024 онд Нийт хураамжийн орлого 28,1 тэрбум төгрөг буюу өмнөх оноос 11.4%-иар өсөж нийт даатгалын зах зээлийн 6%-ийг эзэлж байна. 2024 онд 4,620 харилцагчдад 7.6 тэрбум₮-ийн нөхөн төлбөр олгосон нь өмнөх оноос 17.4%-иар өссөн бөгөөд нийт зах зээлийн 5%-ийг эзэлснээр салбартаа нөхөн төлбөр олголтоор 10 дугаар байрт жагсаж байна.

Компанийн мөнгөн хөрөнгө болон хөрөнгө оруулалт 47,5 тэрбум төгрөгт хүрч, хөрөнгө оруулалтын орлогоор салбартаа тэргүүлэгч нь байсаар байна. “Тэнгэр Даатгал” ХК нь 2024 онд нийт 4,620 харилцагчидад 7.6 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгосон нь өмнөх оноос 54%-иар өссөн бөгөөд нийт нөхөн төлбөрийн тохиолдлын 98%-ийг шийдвэрлэсэн. Үүнээс нийт нөхөн төлбөрийн 63%-ийг тээврийн хэрэгслийн даатгалаар олгосон байна.

Нийгмийн хариуцлагын хүрээнд хийгдсэн ажил:

“Тэнгэр Даатгал” ХК нь нийгмийн хариуцлагын хүрээнд дараах төслүүдийг хэрэгжүүлж байна:

- **ASUUNA**- Өсвөр нас бол эрсдэлтэй зан үйлд татагдах хамгийн өндөр эрсдэлтэй үе байдаг тул энэ хугацаанд хүүхдийг үнэн зөв, баталгаатай, мэргэжлийн мэдээллээр хангах нь чухал юм. Уг хэрэгцээ шаардлагад үндэслэн бид 2022 оноос эхэлж ASUUNA платформыг хэрэглээнд нэвтрүүлээд байна.
- **eDoctor** – Монголын хамгийн анхны эрүүл мэндийн цогц платформ юм. Улс орны хувьд ард иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгож хэрхэн өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх, хамгаалах зэрэг мэдлэгийг олгох нь нэн чухал асуудал байдаг. Уг хэрэгцээ шаардлагад үндэслэн бид бүх насныханд зориулсан эрүүл мэндийн боловсрол олгох цогц платформыг нэвтрүүлсэн билээ. Бид өдгөө 1.5 сая гаруй тогтмол уншигчтай болсон бөгөөд мэргэжлийн эмч нарын бэлтгэсэн 250 гаруй өвчний дэлгэрэнгүй мэдээлэл, 100 гаруй зөвлөмж нийтлэл, шинж тэмдэг дээр суурилсан өвчний асуумж ба зөвлөмж, эрүүл мэндийн тооцоолуур, эмнэлэг хайх зэрэг олон зүйлийг нэг дор багтаасан өргөн мэдээллийн сантай болоод буй.
- **ТЭНГЭР ТӨГӨЛ**- Бид 2021 онд нийт харилцагч, түншүүдтэйгээ хамтран мод тарьж, байнгын усалгаатай төгөл байгуулсан. Тодруулбал Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд 3 га газарт өөрийн нэрэмжит Тэнгэр Төгөлийг байгуулж мод тарих, тохижуулах, усалгааны системийг нь бүрэн шийдэж, тарьсан модны арчилгааг бүрэн хариуцан ажиллаж байна.
- **Амь эрсэдсэн 3 албан хаагчийн ар гэрт мөнгөн тусламж олгов**- Өргөсөн тангарагтаа үнэнчээр зүтгэн, албан үүргээ гүйцэтгэж яваад харамсалтайгаар амь насаа алдсан Баянзүрх дүүргийн Онцгой байдлын алба хаагчдын ар гэрт Тэнгэр Даатгалаас нийт 150 сая төгрөгийн буцалтгүй мөнгөн тусламж олгов. Эдгээр эрсдэлийн баатрууд нь өөр даатгалын компанид даатгалтай байж магадгүй боловч үүнийг үл харгалзан “Тэнгэр Даатгал” ХХК-ийн зүгээс эрсдэлийг бууруулахын төлөө мөр зэрэгцэн зүтгэдэг зорилго нэгт гурван нөхдийнхөө гэгээн дурсгалд зориулан энэхүү мөнгөн тусламж олгов.

2024 онд “Тэнгэр Даатгал” ХК-ийн Гүйцэтгэх удирдлагын баг бизнес төлөвлөгөөний зорилт, стратегийг биелүүлэхийн тулд өөрсдийн нөөц бололцоогоо бүрэн дүүрэн ашиглан ажилласан тул **Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хангалттай гэж дүгнэсүгэй.**

4 ДҮГЭЭР АСУУДАЛ:

Компанийн ногдол ашиг тараах эсэх талаарх ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг танилцуулах;

1. Хэлэлцсэн нь:

Танилцуулсан: “Тэнгэр Даатгал” ХК-ийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Б.Баянмөнх

Танилцуулгын гол агуулга: “Тэнгэр Даатгал” ХК-ийн ТУЗ-ийн 2025 оны 02 сарын 19-ны өдрийн

ээлжит хурлын 25/003 тоот шийдвэрээр ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн болохыг танилцуулав. Нэгж хувьцаанд 67.12 төгрөгийн ногдол ашиг олгох бөгөөд нийт 4,027,200,000.00 төгрөгийн ногдол ашиг хуваарилна. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдөр буюу 2025 оны 04 дүгээр сарын 04-ны өдрөөр тогтоосон. Ногдол ашгийг 2025 оны 04 дугаар сарын 30-ний дотор “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК дахь хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулах байдлаар хуваарилах болохыг мэдэгдэв.

Асуулт, Хариулт

Толоолоо удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга асуулт хариулт эхэлснийг зарлаж тооллогын комиссын даргаас хувьцаа эзэмшигч нараас ирсэн асуултуудыг авав. Цахим хэлбэрээр хувьцаа эзэмшигчдийн хурал явагдаж байгаа тул бүх асуултад хариулах боломжгүй, асуултуудыг агуулгын хувьд ижил болон олон давхацсан асуултуудад хариулахаар сонгосныг тайлбарлав.

Асуулт 1:

Аудитын компаниар “Нексия Глобал Монголиа Аудит” ХХК-г сонгосон шалтгаан?

Хариулт Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Б.Баянмөнх:

“Нексия Глобал Монголиа Аудит” ХХК нь 50 гаруй жилийн туршлагатай 120 гаруй улсад үйл ажиллагаа явуулдаг ТОП түвшний компани юм. Энэхүү компанийн монгол дахь үйл ажиллагаа нь 2019 оноос эхэлсэн ба энэ даатгалын чиглэл, актуар тооцоолол, нөөц сангийн хуваарилалт мөн нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, тайлагнал зэргээр зөвлөмж болон дүгнэлтийн өндөр түвшинд хийдэг компани юм. Тэнгэр Даатгал ХК нь нээлттэй компани учир бид хувьцаа эзэмшигчдийн өмнө хариуцлага хүлээж байгаа тул олон улсын аудитын компани сонгох нь зөв гэж үзсэн.

Асуулт 2:

Цаашид ногдол ашиг тогтмол тараах уу? Эсвэл тухайн жилдээ шийдэж байх уу?

Хариулт Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Б.Баянмөнх:

Даатгалын бизнесийн хувьд манай компани Мандал Санхүүгийн нэгдлийн зарчимтай нийцтэй байгаа гэж харж байгаа. Бидний өгөгч байх, бүтээмжтэй байх, харилцагчийн нүдээр хардаг байх гэх зарчмыг бизнесийн үйл ажиллагаандаа байнга хэрэгжүүлж байгаа. Энэхүү зарчмын хүрээнд ногдол ашгаа хувьцаа эзэмшигчиддээ хуваалцах нь зүйтэй гэж харж байгаа. Тийм ч учраас IPO хийхдээ манай компани ногдол ашиг өгдөг компани болохыг зорьсон, дунд хугацаандаа ч мөн ногдол ашиг өгнө. Мэдээж эдийн засаг уналттай, өсөлттэй байна, эрсдлийн нөхцөл нэмэгдсээр байгаа зэргийг харгалзан тухайн жилийнхээ ашигт ажиллагааны түвшингээс хамааран цаашид ногдол ашиг тараана.

Асуулт 3:

Тэнгэр Даатгал ХК-ийн дунд хугацааны стратеги юу вэ?

Хариулт Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Б.Баянмөнх:

Манай байгууллага дунд хугацаандаа хэрэглээний зээлийн хумих, автомашины даатгал саарах төлөвтэй байна гэж харж байна. Мөн улс орны хувьд экспортын орлогыг бууруулахгүй барих

төлөвтэй байгаа учир илүүтэйгээр хөрөнгийн болон хариуцлагын даатгалын зах зээл тэлэх боломжтой гэж харж байна. Дунд хугацааны хувьд хамгийн гол зүйл бол бидний хүлээж буй даатгалын багц хуулийн өөрчлөлт байгаа. Энэ хууль маань хэрэгжиж эхлэх үед даатгалын суурь бэхжинэ гэж харж байна. Мөн цаашдаа эрүүл мэндийн даатгал, байгууллага хоорондын харилцааг шийдсэн, дунд нь бий болох эрсдлийг бууруулах чиглэлээр үйл ажиллагаагаа тэлэх боломжтой. Энэхүү өсөлтийг дижитал шийдлүүдээр бүтээмжтэйгээр бий болгох боломжтой гэж харж байна.

САНАЛ ХУРААЛТ

Танилцуулсан: Тооллогын комиссын дарга Т.Батмагнай

Танилцуулгын гол агуулга: Санал хураалтын хуудас бөглөх зааварчилгааг хувьцаа эзэмшигчдэд танилцуулав.

КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТАЛААРХ ТУЗ-ИЙН ГАРГАСАН ДҮГНЭЛТИЙГ БАТЛАХАД АСУУДЛААР САНАЛ ХУРААСАН π

“Тэнгэр Даатгал” ХК-ийн 2024 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлахад өгсөн саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 48,923,449 ширхэг хувьцааны санал буюу 100 хувийн саналаар 2024 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлав.

Тооллогын комиссын дарга Т.Батмагнай: Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарч буй тооллогын комиссын тогтоолыг уншиж танилцуулав.

Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга “Тэнгэр Даатгал” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарч буй хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолыг уншиж танилцуулав.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал амжилттай болж дуусаж байгааг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга хэлж, хувьцаа эзэмшигчдийн хуралд идэвхтэй оролцсон хувьцаа эзэмшигч нартаа баяр хүргэн 11 цаг 30 минутад хурал өндөрлөв.

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

Б.ЭНХТҮВИШИН

Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга

ТАНИЛЦСАН:

Ш.ГАНТУЯА

Хурлын дарга

